



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 647

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө худалдах, данснаас
хасаж, худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 6 нэрийн, нийт 192,982.64 (нэг зуун ерэн хоёр мянга есөн зуун наян хоёр ам.доллар жаран дөрвөн цент) ам.долларын балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрч, худалдах (сэлбэг) доод үнийг хавсралтаар тогтоосугай.

2.Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайд, Ерөнхий консул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгө худалдсанаас олох орлогыг зохих журмын дагуу байгууллагынхаа дансанд төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ
132002573
28-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 1-дугаар сарын 2-ны өдрийн
647 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСААС ГАДААД УЛСАД СУУГАА ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРУУДЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАЖ, ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (ам.доллар)	Худалдах доод үнэ (ам.доллар)	Байршил (Элчин сайдын яам)
1	Тоёото Марк-Х, 96-03 /шаргал/ дугаартай, арлын дугаар GRX1306061136	2012.08.01	170895	35,565.89	-	Япон ЭСЯ
2	Genesis маркийн, 075050 дугаартай, арлын дугаар- KMHGL41DBGU156575	2016/2016	135370	18,352.00	800.00	Пусан хотод суугаа КГ
3	Мерседес Бенз Е300, арлын дугаартай WDDHF5FB8EA945499	9/10/2013	76456	49,987.19	1,500.00	Хавана ЭСЯ
4	Коастер автобус, 178 108 дугаартай, LFMH55816CS009685	2012	107644	40,633.53	1,500.00	Бээжин ЭСЯ
5	Жинбэй микро автобус, 178-125 дугаартай, LSYHKBCG6GK026991	2016	90150	35,943.03	1,000.00	
6	Хьюндай соната-6, 089-D00238 дугаартай, KMHET41AP9A605131	2008	106036	12,501.00	500.00	Эрхүү ЕКГ
	НИЙТ ДҮН			192,982.64 (нэг зуун ерэн хоёр мянга есөн зуун наян хоёр ам.доллар жаран дөрвөн цент)	5,300.00 (таван мянга зургаан зуу)	